



БАЙГАЛЬ ОРЧИН  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.  
Resilient nations.



“Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төсөл

Ensuring Sustainability and Resilience (ENSURE) of Green Landscapes in Mongolia

# 2020 оны ажлын гол үр дүн

- Нүүр тулсан сургалтын үр дүнд 13 сумын малчдын бүлгийн 15% орчим буюу 1327 өрхийг хамарсан 227 малчдын бүлэг төсөлд сайн дураар хамрагдлаа
- 227 бүлэг малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх гэрээг 611 мянган г-д байгуулав /Зорилт 300 мянган га/
- Нийт 227 бүлэг өөрсдийн нөөцийг тодорхойлж, бэлчээрийн менежмент, малын чанар, эрүүл мэнд, байгаль хамгаалах 5 жилийн цогц төлөвлөгөөтэй болов
- Төсөлд хамрагдсан 13 суманд МААЭС-н талаар 2020 онд тохирсон зүйл:
- Малчдын үйл ажиллагааг санхүүгийн механизмаар дэмжих үүднээс төслөөс 1 хонин толгой дутам 300 төгрөгөөр тооцсон эх үүсвэр гаргах /нийт 10 орчим сая төгрөг/, харин малчид 1 хонин толгой дутам 500 төгрөгөөр тооцсон хандивыг гарган нийт 800 төгрөгийн сан үүсгэж дараах зүйлд зарцуулах санал дэвшүүлснийг 2020 онд малчид, орон нутгийн удирдлага дэмжээд байсан юм. Үүнд:

# Төсөлд хамрагдсан нийт 13 суманд МААЭС-н талаар тохирсон зүйл:

- Зах зээлд борлуулж, мал эмнэлгийн чанар, гарал үүслийн гэрчилгээгээ авч бүртгүүлсэн малын 1 хонин толгой дутам 300 төгрөг буюу борлуулах малын хонин толгой дутам 750 төгрөгийн урамшуулал олгох /ингэснээр малаа сайн борлуулж, малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх талаар бэлчээр ашиглалтын гэрээгээр үлээсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг болно/
- Бэлчээрийн менежмент, бэлчээрийн менежмент, тэжээл бэлтгэх зэрэг малын эрсдэлээс хамгаалах, малын чанар, эрүүл мэндийг сайжруулах, байгаль хамгаалах зэрэг орон нутгийн хөгжлийн сангаар зарцуулбал зохих үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр малчдаас гарах саналыг хэрэгжүүлэхэд зориулж, 1 хонин толгойд 365 төгрөгийн санхүүжилтийг зарцуулах
- Үлдэх 1 хонин толгойд 135 төгрөг / $800-300-365=135$ /-ийн санхүүжилтийг сумын мэдэлд үлдээж, бэлчээрийн менежмент, малын эрсдэлээс хамгаалах зэрэг нийтлэг арга хэмжээнд зарцуулах

## МААЭС-г дэмжсэн эсэх: /Төслийн малчид 100% дэмжсэн, сумын дүнгээр:

№	Аймаг, сумын нэр	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	Завхан, Их-Уул	62.7	5.2	32.0
2	Завхан, Тосонцэнгэл	67.6	9.7	22.8
3	Архангай, Батцэнгэл	86.7	2.3	10.9
4	Архангай Өлзийт	72.0	5.8	22.2
5	Архангай, Хайрхан	90.1	4.3	5.6
6	Архангай, Эрдэнэмандал	68.7	4.4	27.0
7	Баянхонгор, Баянцагаан	80.8	4.9	14.3
8	Баянхонгор Баацагаан	56.9	20.5	22.6
9	Говь-Алтайн Чандмань	63.1	3.6	33.3
10	Баянхонгор Баян-Өндөр	63.8	16.6	19.6
11	Баянхонгор Шинэжинст	95.5	0.6	3.9
12	Говь-Алтай Эрдэнэ	75.4	2.8	21.8
13	Говь-Алтай Цогт	88.2	0.5	11.3
	Нийт	73.0	6.7	20.3

## Архангай аймгийн Өлзийт суманд гарсан бодит үр дүн:

- Өлзийт суманд МАА-н эрсдэлийн менежментийн сан байгуулан малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх зорилтыг цогцоор нь хэрэгжүүлэв.
- Гарсан бодит үр дүн:

Төслийн малчдын 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын төрөл	2019 он		2020 он		Зөрүү %
	бодит толгой	хонин толгой	бодит толгой	хонин толгой	
Тэмээ	14	70	15	75	7.1
Адуу	3702	25914	3113	21791	-15.9
Үхэр	2505	15030	1924	11544	-23.2
Хонь	28900	28900	21632	21632	-25.1
Ямаа	15833	14250	12357	11121	-22.0
Дүн	50954	84164	39041	66163	-21.4

Өлзийт сумын 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын төрөл	2019 он		2020 он		Зөрүү %
	бодит толгой	хонин толгой	бодит толгой	хонин толгой	
Тэмээ	215	1075	192	960	-10.7
Адуу	21323	149261	19610	137270	-8.0
Үхэр	16535	99210	15372	92232	-7.0
Хонь	206563	206563	187991	187991	-9.0
Ямаа	108604	97744	101448	91303	-6.6
Дүн	353240	553853	324613	509756	-8.0

Төслийн бус малчдын 2020 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын төрөл	2019 он		2020 он		Зөрүү %
	бодит толгой	хонин толгой	бодит толгой	хонин толгой	
Тэмээ	201	1005	177	885	-11.9
Адуу	17621	123347	16497	115479	-6.4
Үхэр	14030	84180	13448	80688	-4.1
Хонь	177663	177663	166359	166359	-6.4
Ямаа	92771	83494	89091	80182	-4.0
Дүн	302286	469689	285572	443593	-5.6

- Төсөлд хамрагдсан малчид сумын нийт нутгаар тарж, багуудын төлөөллийг хамарч нутаглаж байгаа тул төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй малчид байгаль цаг агаар, нийгэм-эдийн засгийн ижил нөхцөлд байсныг нотолж байна. Иймд малын тооны зөрүү болох 15.8 пунктийн ялгааг төслийн үйл ажиллагааны үр дүн гэж баталгаатай хэлж болох юм.
- Ийнхүү Өлзийт сумын малчид малын тоог цөөлөх зорилтыг 24445 га нутаг давуулан биелүүлсэн нь малын тоог цөөлөх төслөөс дэвшүүлсэн загвар амьдралд хэрэгжих боломжтой харуулж чадлаа.

# 2021 онд гүйцэтгэх ажлын зорилт

## I улирал:

- Хангайн бүсийн 6 суманд сонгосон малчдын бүлгийн зун-намрын бэлчээр, гишүүдийн хамаарлын судалгаа, 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхжуудах сургалт
- Говийн бүсийн 7 суманд сонгосон малчдын бүлгийн 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхжуудах сургалт
- Нийт 13 сумын шинэ удирдлагад төслийн талаар танилцуулах, бэлчээрийн менежментийн төлөвлөлтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх
- Малчдын бүлэгтэй байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээг газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлэх, сумдын газрын даамалтай хамтран /ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны зааврын дагуу/

## Үлдэх хугацаанд:

- Малчдын 227 бүлгийн баталсан 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх зорилтыг малын толгойн тооны татвартай болсон эрх зүйн шинэ орчинд хэрэгжүүлэх
- 2022 оны 13 сумын бэлчээрийн менежментийн жилийн төлөвлөгөөг төсөлд хамрагдсан малчдын оролцоотойгоор жишиг байдлаар боловсруулах

## **Малын толгойн тооны албан татварын талаар**

2021 оны 1-р сарын 1-с нэг толгой малаас 0-2000 төгрөгийн татвар авах малын толгойн тооны татварын хууль хэрэгжиж байна. 1 малаас хэдэн төгрөг авахаа сумд өөрсдөө шийдэх боловч татварын орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд бэлчээрийн менежмент, тэжээл бэлтгэх зэрэг малын эрсдэлээс хамгаалах, малын чанар, эрүүл мэндийг сайжруулах, байгаль хамгаалахад зарцуулах учиртай. Энэ талаар дэлгэрэнгүй орон нутгийн хөгжлийн сангийн журмыг Сангийн яамны зүгээс боловсруулж байна.

# Малын татварын хуулийг хэрэгжүүлэх талаарх зөвлөмж

## Татварыг тооцох талаар:

Татварын талаарх олон улсын нийтлэг зарчим: тэгш байх, тодорхой ойлгомжтой байх, хэрэгжүүлэхэд хялбар зардал бага шаардах, татвараас зайлсхийх боломжгүй байх, уян хатан байх

Санал болгож буй хувилбар /МАНЭС-н хуваарьтай ижил бөгөөд хэрэгжих боломжтой нь туршилтаар батлагдсан/

- 1 хонин толгойд ногдох татварыг 800 төгрөгөөр тооцох
- Хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр- бод 2.5, ямаа 1.5, хонь 1
- Малын төрлөөр тооцох татвар- бод 2000, ямаа 1250, хонь 800 төгрөг

## Татварын орлогыг зарцуулах чиглэл:

1. бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах, хэвийн хэмжээнд барих, бэлчээрийн менежментийг сайжруулах;
2. бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
3. малын эрүүл мэндийг хамгаалах;
4. малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
5. малын чанарыг сайжруулах;
6. гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
7. хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
8. малын тэжээлийн ургамал тариалах;
9. тэжээлийн нөөц бүрдүүлэх;
10. байгаль орчныг хамгаалах;
11. хортон мэрэгчидтэй тэмцэх;
12. малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

## **Малын татварын хуулийг хэрэгжүүлэх талаарх зөвлөмж**

### **Татварын орлогыг зарцуулах хуваарь:**

1. Нийт хөрөнгийн 37.5%-г малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх зорилгоор малчин өрхөд олгох мал борлуулсны урамшуулалд
2. Нийт хөрөнгийн 45%-г малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхээс бусад чиг үүргийн хүрээнд малчин өрх, аль эсвэл малчин өрхийн саналыг тусгасан тэдний төлөөллийн байгууллагаас гаргасан саналыг хэрэгжүүлэхэд
3. Нийт хөрөнгийн 17.5%-г хуулиар заасан чиг үүргийн хүрээнд сум, дүүргийн нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж тус тус зарцуулна.
4. 3-д заасан сум, дүүргийн нийтлэг арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг Засаг дарга зохион байгуулна.
5. Малын тоог бэлчээрийн даацаас хэтрүүлээгүй малчин өрхөд энэхүү журмын 1-д заасан урамшууллыг олгохгүй бөгөөд ногдох хөрөнгийг 2-д заасан арга хэмжээнд зарцуулна.

### **Дээрх зарчмаар хуваарилсан тохиолдолд гарах үр дүн:**

- Дунджаар 1 сум 240 сая төгрөг бүрдүүлж, үүнээс:
- 90 саяыг мал борлуулсны урамшуулалд малчдад
- 108 саяыг малчдаас гарах байгаль хамгаалах, бэлчээр, эрсдэл, МАА-н менежмент зэрэг хуулийн дагаах чиг үүргийн саналыг санхүүжүүлэхээр малчдад
- 42 саяыг орон нутгийн мэдэлд үлдээж сум, багийн нийтлэг арга хэмжээ, байгаль хамгаалал, бэлчээр, эрсдэл, МАА-н менежментийн урсгал зардал /томилолт, унаа гм/-г санхүүжүүлэх

Анхаарал тавьсанд баярлалаа